

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ (2023 оны хоёрдугаар сарын 15-ны байдлаар)

Б.Батмөнх<sup>1</sup>, Г.Ханболд<sup>2</sup>

*JEL ангилал:*

F01, F43, F51

*Түлхүүр үг:*

глобал эдийн засаг,  
инфляц, түүхий эдийн үнэ

*Хураангуй:*

Энэхүү тоймд глобал эдийн засагт гарч буй өөрчлөлт, улс орнуудын эдийн засаг, инфляцын төлөв байдал болон түүхий эдийн үнийн өөрчлөлтийн талаар товч мэдээлж байна.

### 1. Гадаад орчны төлөв

#### 1.1. Эдийн засгийн өсөлт

Дэлхийн банкнаас гаргадаг Дэлхийн эдийн засгийн төлөвийн шинэчилсэн тайлан (Global Economic Prospects)-д глобал эдийн засгийн өсөлт цаашид үргэлжлэн буурах төлөвтэй байгааг онцолсон бол ОУВС эсрэгээр дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө сайжруулаад байна. Дэлхийн банкны 2023 оны нэгдүгээр сарын 14-ний шинэчилсэн төсөөллөөр глобал эдийн засгийн өсөлт 2023 онд 1.7 хувьд хүрэх нь өмнөх төсөөллөөс 1.3 нэгж хувиар муудсан төсөөлөл юм. ОХУ-Украины мөргөлдөөн цаашид хурцдах болон инфляцыг тогтворжуулах зорилгоор төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөө хүчтэй илрэх нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг огцом муутгах гол шалтгаан болохоор байна. Тус тайланд дурдсанаар инфляц эрчимжих, нийлүүлэлтийн сүлжээний доголдол даамжрах эсэх болон төв банкуудын бодлогын мөнгөний бодлогын шийдвэр цаашид хэрхэн өөрчлөгдөх зэрэг нь глобал эдийн засагт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

Харин ОУВС-гийн 2023 оны нэгдүгээр сарын 31-ний шинэчилсэн төсөөлөл (World Economic Outlook Update)-өөр дэлхийн эдийн засгийн өсөлт 2023 онд 2.9 хувьд хүрэх буюу өмнөх аравдугаар сарын төсөөллөөс 0.2 нэгж хувиар сайжирлаа. Дэлхийд хэрэглээгээр тэргүүлэгч БНХАУ-д “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалтын арга хэмжээ суларснаар эрэлт нэмэгдэх, мөн аж үйлдвэрлэл

<sup>1</sup> Монголбанкны Мөнгөний бодлогын газрын ахлах эдийн засагч.

Цахим шуудан: batmunkh.b@mongolbank.mn

<sup>2</sup> Монголбанкны Мөнгөний бодлогын газрын эдийн засагч.

Цахим шуудан: khanbold.g@mongolbank.mn

сэргэхээр хүлээгдэж байгаагаас шалтгаалан өсөлтийн төлөвийг нэмэгдүүлжээ. Тус тайланд дурдсанаар БНХАУ-д цар тахлын нөхцөл байдал эргэн муудах, ОХУ-Украины мөргөлдөөн даамжрах, дэлхийн санхүүгийн нөхцөл үргэлжлэн чангарах эрсдэлүүд нь глобал эдийн засгийн төлөвийг муутгах гол эрсдэл болж байна.

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл болон шинэчилсэн төсөөллийг дараах хэсэгт тайлбарлая.

**БНХАУ:** БНХАУ-ын Статистикийн хорооноос тус улсын эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 2022 онд 3.0 хувьд хүрч, зорилтот 5.5 хувийн түвшнээс доогуур байсныг зарлалаа. Энэ нь “Ковид-19” цар тахлын үеийг эс тооцвол 1976 оноос хойших хамгийн бага өсөлт юм. Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, эрэлт буурах, дэлхий дахинд үүсээд буй нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэх эрсдэлтэй байгаа нь өсөлтийн цаашдын төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүйг шинжээчид онцолж байна. БНХАУ 2023 оны эдийн засгийн өсөлтийн төлөвлөгөөг ирэх гуравдугаар сард Ардын намын их хурлаар зарлахаар байна.

**АНУ:** Урьдчилсан гүйцэтгэлээр АНУ-ын эдийн засгийн өсөлт 2022 онд 2.1 хувьд хүрч, шинжээчдийн таамаглалаас өндөр байлаа. ОУВС-аас тус улсын 2023 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 0.5 хувь болгож, өмнөх төсөөллөөс 1.9 нэгж хувиар бууруулжээ. Хэдийгээр инфляц 2022 оны сүүлээс саарч эхэлсэн хэдий ч бодлогын хүүг сүүлийн 40 жилд байгаагүйгээр хурдтай нэмэгдүүлсэн арга хэмжээний нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийн төсөөллийг ийнхүү бууруулсан байна. Мөн Economist Intelligence Unit (EIU)<sup>3</sup>-ийн шинжээчид 2023 оны эхний хагаст АНУ-д эдийн засгийн хямрал нүүрлэж болзошгүй тухай анхааруулж байна.

**Евро бүс:** Евро бүсийн эдийн засгийн өсөлт урьдчилсан байдлаар 2022 онд 3.5 хувь гарч, хүлээлтээс өндөр гарлаа. ОХУ-Украины мөргөлдөөнөөс шалтгаалсан эрчим хүчний үнийн өсөлт нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй хэвээр байгаа ч аялал жуулчлалын орлого, зарим аж үйлдвэрийн салбарын өсөлт төсөөллөөс өндөр байсан нь эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс сайн гарахад нөлөөлжээ. Гэхдээ зарим шинжээчдийн үзэж буйгаар Европын холбооны орнуудын эдийн засгийн идэвхжил суларч байгаа нь 2023 онд үргэлжлэхийг онцолж байна.

**ОХУ:** ОХУ-ын төв банкны ерөнхийлөгч 2022 онд ДНБ 3 хувиар агшсан тухай мэдээллээ. ОХУ-Украины мөргөлдөөнөөс өмнө ОХУ-ын эдийн засаг ойролцоогоор 3 орчим хувиар өсөхөөр тооцоолж байжээ. Мөн Европын холбооны хоригийн улмаас тус улсын байгалийн хий болон газрын тосны экспорт багассан тул өнгөрсөн оны сүүл үеэс эхлэн рублийн ханш ам.долларын

<sup>3</sup> <https://www.eiu.com/n/>

эсрэг сулрах нөлөөг үзүүлсэн байна.

## 1.2. Инфляц

**БНХАУ:** Тус улсад инфляцын түвшин 2022 оны 12 дугаар сард 1.8 хувь хүрч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар нэмэгдлээ. Үүнд “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалтууд суларсантай холбоотойгоор дотоод эрэлт сэргэж байгаа нь нөлөөллөө. Хүнсний үнийн жилийн өсөлт 12 дугаар сард 4.8 хувь гарч, өмнөх сараас 1.1 нэгж хувиар нэмэгдээд байна. Мөн суурь инфляц 12 дугаар сард 0.7 болж, 0.1 нэгж хувиар нэмэгджээ.

**АНУ:** Инфляцын түвшин зургаа дахь сардаа дараалан буурч, 2022 оны 12 дугаар сард 6.5 хувьд хүрлээ. Гэхдээ нийтийн хоол болон хүнсний инфляцыг хасаж тооцсон суурь инфляц 5.7 хувь гарсан нь өмнөх сараас 0.3 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм. Инфляцыг бууруулах, инфляцын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар өсгөн, 4.75 хувьд хүргэх шийдвэрийг 2023 оны хоёрдугаар сарын 1-ний хурлаар гаргаад байна. 2023 оны эхний хагас гэхэд бодлогын хүүний түвшнийг 5.5 хувьд хүргэж, цаашид аажмаар бууруулах төлөвтэй байгааг шинжээчид таамаглаж байна.

**Евро бүс:** Евро бүсийн инфляцын түвшин 12 дугаар сард 9.2 хувь болж, өмнөх сараас 0.9 нэгж хувиар буурлаа. Харин эрчим хүчний үнийн өсөлт 25.7 хувьд хүрсэн нь инфляцыг өндөр түвшинд хадгалагдах гол хүчин зүйл болж байна. Хэдийгээр Евро бүсийн инфляцын түвшин буурсан ч тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг Европын төв банкны ерөнхийлөгч мэдэгдэж байна. Европын төв банкнаас бодлогын хүүг хоёрдугаар сарын 5-ны хурлаар 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 3 хувьд хүргэжээ.

**ОХУ:** ОХУ-ын инфляцын түвшин 2022 оны дөрөвдүгээр сараас хойш үргэлжлэн буурч, 11.9 хувьд хүрээд байна. ОХУ-ын бодлогын хүүний түвшин 7.5 хувь байгаа бөгөөд 2023 оны эхний хагас хүртэл бодлогын хүүгээ өөрчлөхгүй гэж ЕЦУ-ийн судлаачид таамаглаж байна.

## 2. Хүнсний үнийн индекс

**Дэлхийн хүнсний үнэ тайлант сард үргэлжлэн буурлаа.** НҮБ-ын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас гаргадаг дэлхийн хүнсний үнийн дундаж индекс<sup>4</sup> сүүлийн арван сар дараалан буурч, 2023 оны нэгдүгээр сарын байдлаар 131.2-д хүрлээ (Зураг 1). Хүнсний үнийн индекс нэгдүгээр сард буурсанд тос, тосон бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүний үнэ голчлон нөлөөллөө. Хүнсний үнэ ийнхүү буурч байгаа ч цар тахлын өмнөх хэвийн үеийн түвшнээс 30 орчим хувиар өндөр байна.<sup>5</sup>

<sup>4</sup> Энэ индекс нь 2014-2016 оны жигнэсэн дундаж үнийг суурь үе буюу 100 гэж үздэг.


<sup>5</sup> Цар тахлын өмнөх үе буюу 2014-2019 онд индексийн утга 100-н орчимд хэлбэлзэж байв.

Бүтээгдэхүүн бүрээр дэлгэрүүлж тайлбарлавал:

- **Махны үнийн индекс** (35 хувь) Долоо дахь сардаа дараалан буурч нэгдүгээр сард дунджаар 131.2 нэгжид хүрсэн хэдий ч жилийн өмнөх түвшнээс 1.3 хувиар өндөр байна. Махны үнийн индекс буурахад үхэр болон шувууны махны үнийн бууралт нөлөөллөө. Тодруулбал, томоохон нийлүүлэгч орнуудын үхрийн махны нядалгааны хэмжээ нэмэгдсэн тул нийлүүлэлт нэмэгдэж, үнэ буурлаа.
- **Үр тарианы үнийн индекс** (27 хувь) Нэгдүгээр сард өмнөх сараас 0.1 хувиар нэмэгдэж, 147.4 нэгжид хүрч харьцангуй тогтвортой байлаа. Азийн орнуудад будааны эрэлт өндөр байсантай холбоотойгоор үнэ өмнөх сараас 6.2 хувиар өсжээ. Эрдэнэшишийн үнийн хувьд Аргентин улсад тохиож буй хэт хуурайшил нь нийлүүлэлтийг бага зэрэг багасгах нөлөөг үзүүлж байгаа хэдий ч Бразил улсын экспорт нэмэгдэж байгаа нь нийлүүлэлтийг илүү ихээр тэтгэж байна.

Зураг 1

Дэлхийн хүсний үнийн индекс<sup>6</sup>



Эх сурвалж: НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

- **Тос, тосон бүтээгдэхүүний үнийн индекс** (14 хувь) тайлант сард дунджаар 140.4 нэгж болж, өмнөх сараас 2.9 хувиар буурснаар 2021 оны хоёрдугаар сараас хойших хамгийн доод түвшинд хүрлээ. Үнийн индексийн бууралтад далдуу мод, шар буурцаг, рапс, наранцэцгийн

<sup>6</sup> 2014-2016 оны дундаж үнийг суурь болгон хүсний үнийн индексийг тооцсон.

тосны үнүүд нөлөөлөв. Нэгдүгээр сард дэлхийд далдуу модны эрэлт бага байсантай холбоотойгоор үнэ буурсан байна. Мөн Аргентинд цаг агаарын байдал сайжирч, ургац нэмэгдэх хүлээлттэй байгаа тул буурцгийн тосны нийлүүлэлт нэмэгдэн үнэ буурахаар байна.

- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн индекс** (17 хувь) тайлант сард өмнөх сараас 1.4 хувиар буурсан ч өмнөх жилийн мөн үеэс 1.6 хувиар өндөр байна. Сүүн бүтээгдэхүүний үнэ буурахад цөцгийн тос болон хуурай сүүний үнэ голчлон нөлөөллөө. Тухайлбал, Ази, Номхон далайн орнуудын сүүн бүтээгдэхүүний гарц нэмэгдсэн нь цөцгийн тосны үнэд буурах нөлөөг үзүүлжээ.
- **Элсэн чихрийн үнийн индекс** (7 хувь) өмнөх сараас 1.3 хувиар буурч, нэгдүгээр сард дунджаар 115.8 нэгжид хүрлээ. Тайланд улсад чихрийн нишингийн ургац хураалт нэмэгдсэн, Бразил улсад цаг агаарын нөхцөл сайн байгаа зэрэг нь нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үнэ буурах нөлөөг үзүүлжээ.

### III. Түүхий эдийн үнэд гарсан өөрчлөлтийн тойм

Хүснэгт 2

Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт (2023 оны хоёрдугаар сарын 10-ны байдлаар)

Түүхий эдийн төрөл	Үнэ, \$	Өөрчлөлт, %			
		Өдөр	7 хоног	сар	жил
Зэс	<b>8858</b>	-1.4	-1.4	-0.6	-10.8
	Зэсийн үнэ нэгдүгээр сард сүүлийн долоон сарын хамгийн өндөр түвшинд хүрч нэмэгдлээ. Үүнд БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсны улмаас хүлээлт сайжирч, ам.долларын ханш суларч байгаа нь зэсийн үнэ нэмэгдэхэд нөлөөлжээ. Харин сүүлийн өдрүүдэд БНХАУ-д цагаан сарын баяр болж буйтай холбоотойгоор зэсийн үнэ буурах нөлөөтэй байлаа.				
Төмрийн хүдэр	<b>116.3</b>	-0.5	0.1	4.5	-12.1
	Төмрийн хүдрийн үнэ зэсийн үнийн адил нэгдүгээр сард сүүлийн долоон сарын хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. БНХАУ-д 12 дугаар сард аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хүлээлтээс давж, “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсан зэрэг нь цаашид төмрийн хүдрийн үнийг нэмэгдүүлэхээр байна.				
Алт	<b>1866</b>	0.2	-	-0.6	-1.7
	Алтны үнэ нэгдүгээр сарын сүүлээр өсөж, сүүлийн есөн сарын хамгийн өндөр түвшинд хүрсэн. Глобал орчинд ОХУ-Украины мөргөлдөөний улмаас тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа тул алтны үнэ цаашид өсөх магадлалтай байна.				
Газрын тос (Брент)	<b>86.4</b>	2.2	8.0	8.0	-7.1
	Хөл хорио сулран БНХАУ-ын дотоод эрэлт өндөр байх хүлээлтээс шалтгаалан брент газрын тосны үнэ нэмэгдсэн байна. Мөн барууны орнуудын ОХУ-д тавьсан газрын тосны хориг нийлүүлэлтийн талын тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.				

	<b>212</b>	<i>3.9</i>	<i>-3.1</i>	<i>14.5</i>	<i>-23.6</i>
Коксжих нүүрс	Гангийн үйлдвэрлэлийн гол орц болох коксжих нүүрсний эрэлт БНХАУ-ын эрэлт сэргэхтэй холбоотойгоор нэмэгдэх хандлагатай байна. Мөн БНХАУ Австрали улсаас импортлох нүүрсний хоригийг цуцалж, экспортоо сэргээх талаар хэлэлцээр хийсэн тул коксжих нүүрсний үнэ буурч болзошгүй байна.				

**Ном зүй:**

- [1] A Resilient European Economy (csis.org)
- [2] China GDP Annual Growth Rate - 2022 Data - 2023 Forecast - 1989-2021 Historical (tradingeconomics.com)
- [3] What Really Happened With Russia’s Economy in 2022? - The Moscow Times  
Inflation euro zone December 2022 drops as energy costs ease (cnbc.com)
- [4] METALS-Demand recovery hopes help copper towards seven-month high | Reuters
- [5] Oil prices steady after smaller-than-expected U.S. crude build | Reuters